

ДеФакто **ТОЙМ**

ГАЗРЫН ШИНЭТГЭЛИЙН ҮНДЭСНИЙ
ХОРОО БАЙГУУЛАГДАВ

НӨХӨН СОНГУУЛИЙН ТОВ
ЗАРЛАСАН НЬ ҮНДСЭН
ХҮҮЛЬ ЗӨРЧЖЭЭ

САЙД АСАН З.БАЯНСЭЛЭНГЭ АЛБАН
ТУШААЛАА УРВУУЛАН АШИГЛАСАН

V НҮҮРТ

ДеФакто **НИЙТЛЭЛ**

Д.Жаргалсайхан
Эдийн засагч, нийтлэлч

Отгонтэнгэр хайрханыг зорьсон
ЗАМЫН ТЭМДЭГЛЭЛ

II НҮҮРТ

The Defacto Gazette

МЭДЭЭЛНЭ | ЗОРИГЖУУЛНА | МЭДЭЛЖҮҮЛНЭ

Лхагва, 2018.08.29, №61

УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ, БИЕ ДААСАН, УЛС ТӨРИЙН
НАМААС ХАРААТ БУС ДОЛОО ХОНОГ ТУТМЫН СОНИН

www.defacto.mn

Отгонтэнгэр хайрханыг зорьсон
ЗАМЫН ТЭМДЭГЛЭЛ

Отгонтэнгэр хайрхан Даян уулнаас харагдаж буй нь

Дамбадаржаагийн **ЖАРГАЛСАЙХАН**Долоо хоног бүрийн нийтлэл,
<http://jargaldefacto.com/category/23>

Отгонтэнгэр
хайрханыг зорьсон

ЗАМЫН ТЭМДЭГЛЭЛ



Хангайн нурууны ноён оргил Отгонтэнгэр хайрханд баруун хойд талаас нь бараалхахаар өнгөрсөн долоо хоногт Завхан аймгийг зорив. Далайн түвшнээс дээш 4031 метрийн өндөрт сүндэрлэх оргилынх нь урд тал нь мөнх цастай бол хойд тал нь цавчим эгц хадтай ажээ.

“Эргэн тойронд нь бараг мянган км² газрыг 1992 оноос дархалсан учир Отгонтэнгэр хайрханы орчимд хүн, мал нутагладаггүй, онгон сайхан газар болжээ. Улиастайгаас зүүн урагш зуугаад км яваад Даян уулын оройд гарахад цэлмэг тэнгэрийг

эзэгнэсэн хайрхан уул сүр жавхаатай тодрон,
сэтгэлийн баясал төрүүлэв.”

Завхан аймаг нь хангай говь хослон, ой ус нь тэгширсэн үзэсгэлэн төгс байгальтай, хол ойрын аялагч, жуулчид ихтэй байна. Газар нутаг нь 82.5 мянган км² буюу Австри улстай адил, хүн ам нь 80 мянга ажээ. Завханы замд харсан зарим содон үйл явдлыг эргэцүүлэн бодсоноо уншигч тантай хуваалцахыг зорьлоо.

ЗАГАСТАЙН ДАВААНЫ ЗАСЧ ДУУСДАГГҮЙ ЗАМ

Зам үнэхээр хөгжил авчирдаг юм байна гэж Архангай аймгийн Тариат сумын нутаг, Тэрхийн цагаан нуурын дэргэд зусч байгаа малчин эр хуучлав. УБ-тай холбосон шинэ засмалаар зорчих

аялагчид улам олширч, тэдэнд хоол ундаар үйлчилж буй эндэхийн олон хот айл энэ жил бузгай сайн орлоготой гэнэ.



- Харин Завханы Улиастайн иргэд тэр хөгжил нь хэзээ ирэхийг хүлээгээд олон жил болжээ. Уг нь нийслэлээс гарсан хатуу хучилттай зам мянгаад км явж Тосонцэнгэл суманд ирсэн. Урагшаа гучаад км замын ажил дуусаагүй учир шороон замаар бараг цаг хагас сэгсчүүлэв. Тэгээд гэнэт толь шиг сайхан шинэ зам дээр гарч Тэлмэн сумыг дайран зуугаад км жирийлгэн баярлуулсан ч Загастайн давааны наад бэл хүрээд дуусав.

“Цааш аймгийн төв хүртэлх 67 км энэхүү шороон зам машин, жолооч хоёрын хич, тэвчээрийг шалгасан томоохон сорилт болов. Огцом өгсөлт, уруутай, цочмог эргэлт, тасралтгүй овор товонтой туулахад их хэцүү энэ замыг тас харанхуй шөнөөр 2 цаг явж барав.”

Замын энэ хэсгийг барих гэж олон компани солигдож, олон ч жил болжээ. Хөгжлийн банкны санхүүжилт засаг солигдохоор зогсож, төсвөөс

гаргана гэсээр хэдэн жил хий хүлээгджээ. Харин өнгөрсөн сараас Хятадын Эксим банкны зээлд хамрагдаж, хятадын компани барих болжээ. Гэхдээ л замын зөвлөх компанийн зардал, 2.5 тэрбум төгрөгийг 2019 оны төсөвт тусгаж чадвал, энэ зам 2020 онд нэг юм дуусах төлөвтэй.

Завханыхан засмал замаа, дагаж ирэх хөгжлөө харуулдан хорин он гартал хоног тоолон хүлээж сууна. Уг нь энэ замыг төлөвлөж байсан шигээ арван жилийн өмнө дуусгачихсан бол хөдөлмөрийн бүтээмж эрс өсч, бизнес илт сэргэж, ялангуяа аялал жуулчлал ихээхэн хөгжих байлаа.

Төр засаг нь тооцоогүй өрөнд баригдан, төсвийн орлогын дөрөвний нэг нь зөвхөн хүүгийн зардалд нь явж байсан учир төрийн санхүүжилт бүхий замын хөрөнгө оруулалт хамгийн түрүүн танагдаж ирсний тод жишээ нь Завханы зам ажээ.

ЗАВХАНЫГ ГЭРЭЛТҮҮЛСЭН БОГДЫН ГОЛЫН СТАНЦ

Завхан аймаг тогтмол цахилгаангүй, хязгаарлалттай ажиллуулдаг дизелийн мотороор гэрэл залгуулж байлаа.

“1994 онд Монгол инженерцүд Алдархаан сумын нутаг дахь түргэн урсгалтай Богдын гол дээр бага оврын усан цахилгаан станц (УЦС) байгуулжээ. Энэ станцын суваг, хоолойг 2005 онд Германы буцалтгүй тусламжийн хөрөнгөөр засварлаж цйл ажиллагааг нь сайжруулснаар Улиастай хотынхон зундаа цахилгаанаар тасрахгүй, өвөлдөө Майширын УЦС-тай холбогдох болжээ.”

Аймгийн төвөөс зүүн урагш 36 км зайд орших, 2 мегаваттын чадалтай энэ УЦС-ын техникийн шийдэл их өвөрмөц ажээ. Богдын голын өндөр хясаатай нэгэн эргэлт дээр 2.5 км-ын алсаас салаалан суваг татаж, усыг нь тойруу замаар урсгалын хүчээр нь урсган, бага багаар өгсүүлсээр өндөр толгой дээрх усан санг дүүргэж байна. Толгойн цаад талын огцом уналттай налуу дээр хоёр том хоолой уруудан байрлуулж, бэлд нь турбин тавьж цахилгаан үйлдвэрлэж байна. Толгойн зүүн хажуу болох 17 метрийн өндөр хясаанаас хальсан усаа унагаснаар хүний гараар бүтээсэн хүрхрээ

бий болж, байгалийн бас нэг хосгүй үзэсгэлэнг бүрдүүлжээ.



Богдын голын УЦС



- ▶ Энэ бол манай улсад буй уулын голын түргэн урсгалыг ашигласан, бага оврын 11 усан цахилгаан станцын нэг нь. Ашиглах арга ухаанаа олох аваас

Завхан аймагт эрчим хүчний ч, аж үйлдвэрийн ч, аялал жуулчлалын ч салбарыг хөгжүүлэх боломж их буйг харж явлаа.

ЦЭНХЭРИЙН РАШААНЫ ЦЭГЦГҮЙ БААЗУУД

Улаанбаатар хотоос хатуу хучилттай засмал замаар 480, шороон замаар 30 км яваад Архангай аймгийн Цэнхэр сумын алдарт халуун рашаанд очив. Цэнхэрийн рашаан нь халуунаараа Шаргалжуутын дараа ордог, ус нь газрын гүнээс секундэд 10 литр хүртэл ундарч гардаг ажээ. Хүхэрт устөрөгч, цахиурын нэгдэл агуулсан энэ рашаан булчин, үе мөчний өвчин; хөдөлгөөний эрхтэн, зөөлөн эдийн гэмтэл; эрүүл мэнд сэргээх; ядаргаа тайлах; чихрийн шижин өвчний үед эерэг нөлөө үзүүлдэг гэдэг.

Хоёр уулын бэлд байрлах нэг ундаргаас тус бүртээ хоолой татан жижиг сангуудаа рашаанаар өглөө дүүргэж, шөнөдөө сулладаг Цэнхэр жигүүр, Шивээт манхан, Дуут ресорт, Хангай ресорт, Алтан нутаг зэрэг таван ч амралтын бааз хаяа залган орших юм. Захиалгагүй бол өрөө, гэр олдохгүй,

“ОЦОН ШУВУУД”

Улаанбаатараас Улиастай хүртэл мянган км явах замд олон янзын шувууд таарлаа. Элээ, хэрээ, хун, тогоруу, ангир бүр цахлай ч байлаа.

“Тэхдээ хамгийн олон, хамгийн том, хамгийн содон шувуу бол зам дагуу цувран суух “оцон шувууд” байлаа.”

Нэгэнт л бие засах зориулалтын жорлон байхгүй учир зорчигчид “оцон шувуу”-нд хувирахаас өөр сонголтгүй юм. Уг нь бол мянганы замаа дагуулаад аяны алжаалаа тайлж, амсхийх, ариун цэврийн өрөөнд орох, аяга цай, кофе уух үйлчилгээний цогцолбор хэдэн арвыг байгуулчихаж болох байсан. Тийм газруудыг яаж барих тухай үндэсний стандарт “Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ. Авто замын дагуух үйлчилгээний байгууламж, Үндсэн шаардлага” MNS 5537 бүр 2005 онд уг нь батлагдсан ажээ.

Ер нь бол улсын чанартай хатуу хучилттай замын дагуу тодорхой зайд (зуун км тутамд ч юм уу) үйлчилгээний газар барьж, ажиллуулах эрхийг

хоногт нийтдээ 500-аад хүн авдаг энэ баазууд эргэн тойрноо тохижуулах, машины зам талбай засах талаар хамтран ажиллаж чадахгүй байгаа бололтой.

“Хоногт 500 хүн, зуугаад машин ирж байгаа газар бол томоохон суурин бөгөөд хотжилтын талаас нь төлөвлөж цэгцлэх, орох гарах замыг нь хатуу хучилттай болгох, стандартын зогсоол, гэрэлтүүлэг, цэвэр бохир усны шугам, байгууламж хийхгүй бол хайран байгаль айран болж байна.”

Орон нутгийн амралтын болон жуулчны баазуудыг аймагт нь бүртгэх, орлогын татварыг суманд нь үлдээж тухайн байршлын дэд бүтцийг сайжруулахад заавал зарцуулах талаар хууль зүйн зохицуулалт хийх цаг болжээ.

тендэрээр олгох, орон нутгийн засаг захиргаа нь дэмжих, аялал жуулчлалын мэдээлэл түгээх зэрэг ажлыг монголд эхлүүлэх хэрэгтэй байна.

Холбогдох дэд бүтцийг байгуулахын зэрэгцээ аймаг бүр аялал жуулчлалын онцлог бренд бүтээх шаардлагатай. Нутаг усны түүх, дурсгалын газрууд, ёс заншил, соёл, хууч яриа, домогт суурилсан аялалын өөр өөрийн онцлогтой хөтөлбөрийг аймаг бүр зохиож, сурталчилж чадвал аялал жуулчлал ч хөгжинө, түүнийг дагаад орон нутгийн иргэд, аж ахуй нэгжүүд ч бүх талаар хөгжинө. Орон нутгаас нийслэлд ирдэг нүүдлийг Улаанбаатараас аймгууд руу эргүүлэх боломж ч бүрдэж магад.

“Зам дагаж хөгжил ирж байна. Айсуй хөгжлийг ухаалаг төлөвлөх, ард иргэд нь оролцон, аж амьдралаа өргөхийн тулд аймгуудад эдийн засгийн эрх чөлөөг олгох цаг болжээ.”

2018.08.29
УБ-Улиастай-УБ



ДеФакто **ТОЙМ**

Ням гараг бүр VTV телевизээр 19 цагт гардаг Дефакто тоймын эмхэтгэл:
2018.08.26-ны дугаар

Долоо хоног бүрийн тойм, <http://jargaldefacto.com/category/12>

ГАЗРЫН ШИНЭТГЭЛИЙН ҮНДЭСНИЙ ХОРОО БАЙГУУЛАГДАВ

Монгол улсын Засгийн газар 2017 онд тогтоол гаргаж улсын газрын шинэтгэлтэй холбоотой хууль тогтоомж, гэрээ болон бусад баримт бичгүүдийн хэрэгжилтийг хангах, нэгдсэн байдлаар зохион байгуулах чиг цэрэгтэйгээр "Газрын шинэтгэлийн үндэсний хороо"-г байгуулж байсан. Энэ хорооны анхны хуралдаан өнгөрсөн Даваа гарагт болж цйл ажиллагааны төлөвлөгөө, улсын газар зохион байгуулалттай холбоотой ерөнхий төлөвлөгөөний хэлэлцүүлэг явагджээ.

Ямар нэг хороо байгуулагдаад дэвшил гардаг байсан бол аль эрт л нэлээн дэвшил гарчих байсан даа. Газар, усны асуудал бол хөгжлийн суурь асуудал шүү дээ. Энэ чухал асуудлыг хэн ЭЗЭМШИЖ, ӨМЧЛӨЖ, АШИГЛАЖ байгаа нь тодорхой байх ёстой. Хэрвээ тодорхой биш байвал тэр улс оронд авлига цэцэглэдэг. Үүнээс улбаалаад үймээн самуун цаашлаад иргэний дайн ч гарах эрсдэл үүсдэг. Монгол улс газрын асуудлаа шийдэх гэж оролдсон боловч өдийг хүртэл чадаагүй л байна. Газрын шинэтгэлийн үндэсний хороо анхны хуралдаанаа хийсэн гэж байгаа нь бас л нэг оролдлого.

Би энэ хороо газрын асуудлыг бүрэн шийдэж чадна гэж харахгүй байна. Яагаад гэвэл хэрвээ шийдэх байсан бол аль ч Засгийн газрын цед, аль ч намын цед шийдчих байсан. Авлигаа шийдээгүй бол газрын асуудлыг шийднэ гэж байхгүй.

"Сүүлийн жилүүдэд газар олголт эмх замбараагүй явагдсанаас үүдэн дагалдах олон хүндрэл гарч байгааг зайлшгүй цэгцлэх цаг болсон" гэж тус хорооны дарга

Ерөнхий сайд У.Хүрэлсүх хэлсэн. Хулгайлж өгсөн газраа буцааж авч чадахгүй айгаад иргэдэд хүний хөрөнгөд халдахгүй гэж хэлээд байгаа л даа. Монгол улсын бүх газрын тооллого хийгдээгүй, аль хэсгийн ямар хэмжээтэй газар хэнд байгаа нь мэдэгдэхгүй. Хэн нэг хүн 1 га газартай гэсэн гэрчилгээтэй ч яг үнэндээ 5 га газар хашчихдаг. Татвар төлөхдөө 1 га газрын хэмжээгээр төлдөг. Харин амьдрал дээр 5 га газартай байх жишээтэй. Тийм учраас газрыг эхлээд заавал бүртгэх хэрэгтэй дараа нь өмчлөх, эзэмших, ашиглах эрхээр нь ялгадаг. Дараа нь газрын үнэлгээгээ зөв хийж, ил тод байлгаж, татвараа зохих хэмжээгээр нь авч, авсан татварынхаа тал хувийг тухайн орчинг тохижуулахад зориулах ёстой. Бусад бүх соёл иргэншилтэй орнууд энэ аргаар яваад хөгжөөд ирснийг манай дарга нар мэдэж байгаа. Авлигатай байгаа энэ улсад энэ хороог ямар ч Ерөнхий сайд толгойллоо гээд газрын асуудлыг шийдэж чадахгүй. Шийдье гэвэл өөрийн намын нэлээн олон хүнийг ажилгүй болгоод, хариуцлага хүлээлгэх ёстой болно.

НӨХӨН СОНГУУЛИЙН ТОВ ЗАРЛАСАН НЬ ҮНДСЭН ХУУЛЬ ЗӨРЧЖЭЭ

"Монгол улсын их хурлын сонгуулийн 42-р тойрогт нөхөн сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай" УИХ-ын тогтоолын төсөл 2018.06.27-ны өдөр батлагдсан. Тус тогтоол нь Чндсэн хуулийн холбогдох хэсгүүдийг зөрчсөн эсэх тухай маргааныг өнгөрсөн Лхагва гарагт хянаад "төрийн албанд ажиллаж буй иргэдийн сонгогдох эрхийг хязгаарлах, тэгш бус байдлыг цэцгэхээр байна" гэж Цэц шийдвэрлэсэн.

Үндсэн Хуулийн Цэцийн шийдвэрийг УИХ хүлээж авлаа гэж хэлээд нөхөн сонгууль хийхгүй гэж бодож байна. Хэрвээ УИХ 10-р сард хуралдаад нөхөн сонгууль болно гэж үзвэл дараагийн 6-р сард сонгуулийг зарлах болчихно. 2019 оны 6-р сараас 2020 оны 6-р сарын хооронд нэг жилийн хугацаа байгаа. Энэ нэг жилийн дотор сонгууль хийнэ гэж байхгүй шүү дээ. Тэгэхээр эрх баригчид худлаа жүжиг тавьж, хуулиар тоглож байна. Төрийн эрх барьж байгаа Монгол Ардын Намд шууд сонгууль хийх сонирхол байхгүй байгаа. Яагаад гэвэл нөхөн сонгууль хийвэл энэ нам шууд ялагдана шүү

дээ. Ер нь хоёр сонгуулийн дунд болж байгаа сонгууль дараагийн сонгуулийн өнгийг тодорхойлдог. МАН-ын төлөөлөгч нь эмэгтэй хүн хүчиндсэн хэрэгт холбогдоод байхаар хэн дахин тэднийг сонсох юм бэ? Ер нь энэ нам сонгуульд хүнээ өрсөлдүүлэх ёс зүйн эрх ч байхгүй гэж үзэж байгаа. Энэ намын дараагийн төлөөлөгч нь хүн хүчиндэхгүй гэсэн баталгаа хаана байгаа юм бэ?

Хүчингийн хэрэгт холбогдсон улс төрчийг солих гэж хамаг энерги нь явчихаад одоо наана нь утаа ирж байна шүү дээ.

Сонгуулийн Ерөнхий Хороо гэж их сонин газар бий. Нөхөн сонгуульд Иргэний Зориг Ногоон Нам сонгуулийн зардлын тайлангаа өгөөгүйгээс оролцох боломжгүй гэсэн. Тэгвэл оролцох эрх авсан бусад нам нь санхүүгийн тайлангаа өгсөн юм уу? Сонгуулийн Ерөнхий Хорооны [вебсайтад](#) ямар ч намын тайлан ороогүй байгаа шүү дээ. Намуудын сонгуулийн зардлын тайлан төрийн нууц юм уу? Яагаад ил тод биш байгаа юм бэ? Намуудын санхүүгийн тайланд шалгалт хийгээд, хяналт тавиад олон нийтэд ил тод болгоогүйгээс авлига цэцэглээд байна. Сонгуулийн Ерөнхий Хороо гэж биш Сонгогчдын Ерөнхий Хороо гэж байх ёстой.



САЙД АСАН 3.БАЯНСЭЛЭНГЭ АЛБАН ТУШААЛАА УРВУУЛАН АШИГЛАСАН

2014–2016 оны хооронд Барилга хот байгуулалтын сайдаар ажиллаж байсан шүүгдэгч Цагаан овогт Зангадын Баянсэлэнгэ, Боржигон овогт Миеэгомбын Болортуяа нарыг Албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас улсын төсөвт 972,448,955 төгрөгийн хохирол, хүнд хор уришг учруулсан гэмт хэрэг үйлдсэн гэмт буруутайд тооцож, 2002 оны Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 11 дүгээр зүйлийн 11.1, 12 дугаар зүйлийн 12.1, 36 дугаар зүйлийн 36.2 дахь хэсэгт заасныг журамлан тусгай ангийн 263 дугаар зүйлийн 263. 2 дахь хэсэгт зааснаар

- 3.Баянсэлэнгийг төрийн байгууллагад ажиллах эрхийг 3 жилийн хугацаагаар хасч, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 100 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний буюу 19,200,000 төгрөгөөр торгох ялаар,
- М.Болортуяаг төрийн байгууллагад ажиллах эрхийг 1 жилийн хугацаагаар хасч, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 51 нэг дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний буюу 9,792,000 төгрөгөөр торгох ялаар тус тус шийтгэв.
- 972,448,955 төгрөгийг Бэрэн групп ХХК-аас гаргуулж улсын орлогод оруулахаар шийдвэрлэсэн.
- Харин сайд асан 3.Баянсэлэнгэ шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй байгаагаа илэрхийлсэн.

Улс төрийн албан тушаалтнууд ийм төрлийн хэрэгт холбогдохоороо “энэ бол улс төрийн зохиомол хэрэг” гэж мэдэгдэл хийдэг л дээ. Ганц монголд ч биш. Энэ улс төрчид гэдэг хүмүүсийг чинь ард иргэд нь байнга хянахгүй юм бол юу ч ярьж, юу ч хийж мэднэ. Хэрвээ энэ сайд асан 3.Баянсэлэнгэ Монгол Ардын Хувьсгалт Намынх биш Монгол Ардын Нам юм уу Ардчилсан Намын хүн байсан бол асуудал шал ондоо байх байсан. МАН, АН гэсэн хоёр намын гишүүн байсан бол шүүх ингэж ажиллаж, анхаарал өгөхгүй байсан.

Яагаад гэвэл бусад авлига, албан тушаалын хэрэг хийсэн МАН, АН гэсэн хоёр намын гишүүд хэдэн сар шоронд суугаад л, бие нь муудлаа гээд л гараад явчихдаг шүү дээ.

Олон хаадын нэртэй том том бонд, олон улсын байгууллагуудын буцалтгүй тусламжийн мөнгийг аваад алга болсон хүмүүс одоо хаана байгааг бид мэдэхгүй байна шүү дээ. Буруу зүйл хийсэн хэн ч гэсэн яг ижилхэн шийтгэлээ хүлээх ёстой.



NEW NISSAN PATROL

ЛИЗИНГИЙН НӨХЦӨЛ:

Урьдчилгаа 0%

Хүү 1.4%

Хугацаа 84 сар

УРАМШУУЛАЛ:

Хамгаалалтын хууцаг

Салбар сервисын эрх


4ш Овчин дугуй

Салбарны шалтны хамгаалалт

УНЭ: ₮214.0 сая

Дефакто тоймын гол агуулгыг
хураангуйлан бэлтгэв

Тоймын бүрэн эхийг
jargaldefacto.com вебсайтаас
үзэх боломжтой.



JARGAL DEFACTO

ГАР УТАСНЫ АППЛИКЭЙШН

The Defacto Gazette

➤ АНГЛИ

➤ МОНГОЛ

➤ ЯПОН



GOOGLE STORE

APP STORE



Та “Дефакто Газет” цахим сонинг төлбөргүй тогтмол хүлээн авахыг хүсвэл
www.jargaldefacto.com болон www.defacto.mn вебсайтад өөрийн имейлээ бүртгүүлнэ үү.

РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ

Ерөнхий эрхлэгч:
Дамбадаржаагийн Жаргалсайхан

Ерөнхий Редактор:
Ганбаатарын Жавзмаа

ГҮЙЦЭТГЭЛИЙН БАГ

Отгонсүрэнгийн Билгүүн
Адъяагийн Тунгалаг

ХОЛБОО БАРИХ

✉ editor1@jargaldefacto.com

☎ +976 94109342

🌐 www.defacto.mn

www.jargaldefacto.com